



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 07 сарын 22 өдөр

дугаар А/393

Есөнбулаг сум

Шүлхий өвчнөөс сэргийлэх
яаралтай дархлаажуулалтын ажлыг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8 дэх хэсэг, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2026 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн А/203 тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд мэдрэмтгий малд шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг 2026 оны 07 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн 14 хоногийн хугацаанд шуурхай зохион байгуулсугай.

2. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтад хамрагдах малын тоо, шаардагдах вакцины хуваарийг хавсралтаар баталсугай.

3. Яаралтай дархлаажуулалтад орон нутгийн төр захиргааны байгууллагууд, малчид мал бүхий иргэд, аж ахуйн нэгжийг татан оролцуулж, ажиллах хүч, хашаа хороо, тээврийн хэрэгсэл бусад шаардлагатай асуудлыг шуурхай шийдвэрлэж, тогтоосон хугацаанд зохион байгуулж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Шаардагдах вакцин биобэлдмэлийг татан авч хуваарилах, мэргэжил арга зүйгээр хангах, дархлаажуулалтын явцад хяналт тавих, үр дүнг тайлагнаж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Р.Бүрэнбаясах)-д үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Алтангэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

8200010737

Аймгийн Засаг даргын 2026 оны
07 дугаар сарын 08-ны өдрийн 4 дүгээр
захирамжийн хавсралт

ШҮЛХИЙН ВАКЦИНЖУУЛАЛТАД ХАМРАГДАХ
МАЛЫН ТОО, ВАКЦИНЫ ХУВААРЬ

Сумын нэр	Дархлаажуулалтад хамрагдах малын тоо			Шүлхийн вакцин
	Үхэр	Тугал	Нийт мал, амьтан	Олгох тун
Алтай	1,481	278	1,759	1,800
Баян-Уул	8,670	1,763	10,433	10,500
Бигэр	6,946	1,722	8,668	8,700
Бугат	2,026	466	2,492	2,500
Дарив	4,875	1,750	6,625	6,700
Дэлгэр	6,500	1,263	7,763	7,800
Жаргалан	7,576	2,570	10,146	10,200
Тайшир	3,131	946	4,077	4,100
Тонхил	2,908	606	3,514	3,600
Төгрөг	2,856	1,421	4,277	4,300
Халиун	6,368	1,489	7,857	7,900
Хөхморьт	8,053	2,409	10,462	10,500
Цогт	4,748	1,227	5,975	6,000
Цээл	3,321	781	4,102	4,100
Чандмань	3,964	1,220	5,184	5,200
Шарга	6,301	1,689	7,990	8,000
Эрдэнэ	1,607	426	2,033	2,100
Есөнбулаг	4,820	1,276	6,096	6,100
Нийт	86,151	23,302	109,453	110,100

